



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/124

Чингис хот

“Архидалтгүй Хэтийн Хэнтий” арга хэмжээг зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн “а”, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдааны 2020 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.10-т заасан “Архидалтгүй Хэтийн Хэнтий” арга хэмжээг зохион байгуулах зардалд зориулж 10 000 000/ арван сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулах төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. 3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010347

Аймгийн Засаг даргын 2021 оны  
 03 дугаар сарын 05 өдрийн 7/124  
 дугаар захирамжийн хавсралт



“АРХИДАЛТГҮЙ ХЭНТИЙН ХЭНТИЙ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД  
 2021 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨСВИЙН ТООЦОО

Чингис хот

№	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Санхүүжүүлэх эх үүсвэр /сая төгрөг/	Хариуцах байгууллага
1	Хордлого тайлах эмчилгээ, сэтгэл заслын сургалт, архинаас гаргах эмчилгээ	2021 оны 1,2 дугаар улиралд	Хордлого тайлах эмчилгээ, сэтгэл заслын сургалт, архинаас гаргах өвөрмөц эмчилгээ /эспераль хийгдсэн байна.	3.780.000	Аймаг, сумдын ЗДТГ, Нэгдсэн эмнэлэг, “Хэрлэнгийн цэнхэр алс”-ТББ
2	Урьдчилан сэргийлэх ажил, олон нийтийн арга хэмжээ	2021 оны 1,2 дугаар улиралд	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулагдаж иргэд эерэг хандлагатай болох	1.220.000	Хууль, эрх зүйн хэлтэс,
			ЦГ-ын Хэв журмын тасагт компьютертэй болсон байна.	2.000.000	Цагдаагийн газар
3	Аймгийн хэмжээнд сургалт, сурталчилгаа зохион байгуулах	2021 оны 1,2,3,4 дүгээр улиралд	Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, хэрэглээний талаарх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулагдсан байна.	2.000.000	Хууль, эрх зүйн хэлтэс,
4	“Эдгэрлийн баяр хөөр” сэтгэл зүйн сургалт, нэгдсэн арга хэмжээ	2021 оны 4 дүгээр улиралд	Архины асуудлаа шийдсэн иргэд харилцан туршлага солилцох арга хэмжээ зохион байгуулагдсан байна.	1.000.000	“Хэрлэнгийн цэнхэр алс”-ТББ
<b>Нийт дүн</b>				<b>10.000.0000</b>	